

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Хөвсгөл аймгийн Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн  
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
аудитын хураангуй тайлан**

Аудитын код: ХӨА-2026/037/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Мөрөн сум

2026 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Аудитор: Г.Ичинхорлоо

Утас:88688168 Цахим хаяг: [ichinkhorloog@audit.gov.mn](mailto:ichinkhorloog@audit.gov.mn)

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас:99389208 Цахим хаяг: [b\\_myadagmaa@yahoo.com](mailto:b_myadagmaa@yahoo.com)

Аудитор Ц.Мөнхтуяа

Утас: 99382220 Цахим хаяг: [Munkhtuya2220@gmail.com](mailto:Munkhtuya2220@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsGol@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 01/162  
тэнэй \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ  
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГА Л.БАЯРСАЙХАН ТАНАА

#### Хараат бус аудиторын дүгнэлт

##### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

##### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

##### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Жаргалант сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангаас авах 4,033.5 мянган төгрөгийг санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

##### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 156,032.6 мянган төгрөгийн 11 алдаа, зөрчлийг илрүүлж 135,627.4 мянган төгрөгийн 7 алдааг залруулж, 20,405.2 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж, хууль, тогтоомжийн нийцэлтэй холбоотой 2 зөрчилд албан шаардлага өгсөн.

### **Бусад асуудлын хэсэг**

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Жаргалант сумын Эрүүл мэндийн төвтэй байгуулсан анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах 2025 оны гэрээний биелэлтийг 89.1 хувьтай дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А. ЭРДЭНЗБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>296,920,778.23</b>	<b>151,106,956.11</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	19.10	15,529,594.45
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	19.10	15,529,594.45
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	19.10	15,529,594.45
31211	Төрийн сангийн харилцах	19.10	15,529,594.45
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	173,652,307.15	4,333,502.63
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	300,000.00	300,000.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	173,352,307.15	4,033,502.63
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	123,268,451.98	131,243,859.03
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	39,540,212.69	42,771,663.18
35130	Эм боох материал	39,540,212.69	42,771,663.18
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	83,728,239.29	88,472,195.85
35410	Бичиг хэргийн материал	2,541,970.00	2,074,100.00
35420	Аж ахуйн материал	5,027,400.00	5,684,900.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,575,000.00	885,000.00
35440	Түлш, шатах тослох материал	491,412.27	417,702.27
35450	Барилгын засварын материал	8,054,800.00	4,766,800.00
35460	Хүнсний материал	6,137,988.59	4,688,016.59
35470	Бусад хангамжийн материал	58,899,668.43	69,955,676.99
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>850,339,432.94</b>	<b>818,397,998.25</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	850,339,432.94	818,397,998.25
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	835,203,432.94	803,261,998.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	668,023,880.00	668,023,880.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-113,349,434.62	-137,310,196.42
39203	Авто-тээврийн хэрэгсэл	112,340,019.00	111,540,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-29,983,519.40	-39,130,300.44
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	357,413,703.20	366,225,303.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-185,973,690.14	-200,567,443.45
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	59,684,600.00	52,882,600.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-32,952,125.10	-18,402,644.94
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	15,136,000.00	15,136,000.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-550,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	15,136,000.00	15,136,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	00.00	00.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,147,260,211.17</b>	<b>969,504,954.36</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>75,578,789.65</b>	<b>00.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	75,578,789.65	00.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	75,578,789.65	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	21,809,190.31	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	44,712,399.34	00.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	9,057,200.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	9,057,200.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,071,681,421.52</b>	<b>969,504,954.36</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,071,681,421.52	969,504,954.36
511	Засгийн газрын сан/ орон нутгийн сан	385,375,911.00	385,375,911.00
51101	Өмч: - төрийн	385,375,911.00	385,375,911.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	475,613,421.47	373,436,954.31
51210	Өмнөх үеийн үр дүн	475,613,421.47	475,613,421.47
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-102,176,467.16
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	210,692,089.05	210,692,089.05
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,147,260,211.17</b>	<b>969,504,954.36</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,470,716,650.74</b>	<b>1,438,212,181.21</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>215,158,316.57</b>	<b>175,241,507.01</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	215,158,316.57	175,241,507.01
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	215,158,316.57	175,241,507.01
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	32,582,000.00	92,429,207.60
1200017	Үнэ төлбөргүй хүлээж авсан орлого-үндсэн хөрөнгө	145,515,060.00	60,670,000.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээж авсан орлого-бараа материал	41,719,353.10	22,142,299.41
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,255,558,334.17</b>	<b>1,262,970,674.20</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	40,830,500.00	37,583,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	40,830,500.00	37,583,200.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	1,214,727,834.17	1,225,387,474.20
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,214,727,834.17	1,225,387,474.20
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,309,061,437.56</b>	<b>1,540,388,648.37</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,309,061,437.56</b>	<b>1,540,388,648.37</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,276,869,744.56	1,451,793,155.70
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	826,181,737.80	937,197,634.00
210101	Үндсэн цалин	518,304,791.00	541,022,410.00
210102	Нэмэгдэл	230,883,796.80	275,800,564.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	37,621,000.00	62,322,000.00
210104	Урамшуулал	39,372,150.00	58,052,660.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	96,291,570.48	115,167,848.77
210201	Тэтгэврийн даатгал	64,566,151.39	77,946,316.05
210202	Тэтгэмжийн даатгал	8,085,822.38	9,623,211.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,389,231.16	6,121,183.51
210204	Ажилгүйдлийн даатгал	3,673,233.22	4,295,427.89
210205	Эрүүл мэндийн даатгал	14,577,132.33	17,181,709.98
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	34,720,807.00	37,726,910.00
210301	Гэрэл, цахилгаан	3,767,851.00	14,427,864.00
210302	Түлш, халаалт	28,852,956.00	22,776,405.00
210303	Цэвэр, бохир ус	2,100,000.00	522,641.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	82,639,480.93	94,858,976.44
210401	Бичиг хэрэг	4,961,100.00	9,876,060.00
210402	Тээвэр, шатахуун	39,589,470.00	39,389,480.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,400,000.00	3,033,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	1,150,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,912,989.50	15,728,718.41
210408	Бараа материал акталсны зардал	18,775,921.43	25,680,918.03
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	132,249,382.37	110,511,037.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	114,482,704.87	92,925,685.80
210502	Хоол, хүнс	17,766,677.50	17,585,352.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	00.00	30,555,750.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	7,650,950.00
210604	Урсгал засвар	00.00	22,904,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,892,000.00	6,408,700.00
210702	Дотоод албан томилолт	1,892,000.00	6,408,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	15,021,000.00	14,446,464.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,021,000.00	13,418,964.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	942,300.00

210803	Даатгалын үйлчилгээ	00.00	68,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	9,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	8,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>87,873,765.98</b>	<b>104,919,834.69</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,139,900.00	5,390,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	83,733,865.98	99,528,934.69
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>32,191,693.00</b>	<b>88,595,492.67</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>30,582,000.00</b>	<b>88,595,492.67</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	24,101,492.67
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	30,582,000.00	64,494,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,609,693.00</b>	<b>00.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,609,693.00	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>161,655,213.18</u></b>	<b><u>-102,176,467.16</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,675,000.00</b>	<b>00.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	3,675,000.00	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-3,675,000.00</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>157,980,213.18</u></b>	<b><u>-102,176,467.16</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1,133,367,332.02</u></b>	<b><u>1,524,718,686.32</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b><u>32,582,000.00</u></b>	<b><u>92,429,207.60</u></b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	32,582,000.00	92,429,207.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	32,582,000.00	92,429,207.60
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	32,582,000.00	92,429,207.60
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b><u>1,100,785,332.02</u></b>	<b><u>1,432,289,478.72</u></b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	40,830,500.00	37,583,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	40,830,500.00	37,583,200.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	1,059,954,832.02	1,394,706,278.72
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,059,954,832.02	1,394,706,278.72
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>1,122,910,888.44</u></b>	<b><u>1,502,271,610.97</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b><u>1,122,910,888.44</u></b>	<b><u>1,502,271,610.97</u></b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b><u>1,090,719,195.44</u></b>	<b><u>1,413,676,118.30</u></b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	802,763,636.13	958,757,134.00
210101	Үндсэн цалин	515,154,499.31	544,798,525.60
210102	Нэмэгдэл	234,007,486.82	278,046,115.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	37,422,000.00	58,219,733.00
210104	Урамшуулал	16,179,650.00	77,692,760.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	98,224,132.98	115,417,539.08
210201	Тэтгэврийн даатгал	67,036,461.77	79,136,196.49
210202	Тэтгэмжийн даатгал	7,018,080.42	9,325,909.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,844,409.23	5,750,577.76
210204	Ажилгүйдлийн даатгал	3,865,216.16	4,240,951.40
210205	Эрүүл мэндийн даатгал	15,459,965.40	16,963,904.14
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>34,720,807.00</b>	<b>37,653,200.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,767,851.00	10,020,399.00
210302	Түлш, халаалт	28,852,956.00	27,110,160.00
210303	Цэвэр, бохир ус	2,100,000.00	522,641.00

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	52,253,683.13	71,850,216.87
210401	Бичиг хэрэг	2,844,000.00	7,635,960.00
210402	Тээвэр, шатахуун	38,027,883.13	40,877,356.87
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,400,000.00	3,033,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	1,606,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,981,800.00	18,697,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	78,038,036.20	149,720,264.35
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	65,272,136.20	103,725,724.35
210502	Хоол, хүнс	6,965,900.00	27,994,540.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,800,000.00	18,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,500,000.00	36,753,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	5,892,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	10,000,000.00
210604	Урсгал засвар	4,500,000.00	20,860,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,892,000.00	6,408,700.00
210702	Дотоод албан томилолт	1,892,000.00	6,408,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	16,270,900.00	24,203,464.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,021,000.00	21,021,964.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	942,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	68,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	9,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	8,100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,249,900.00	2,154,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,056,000.00	12,912,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,056,000.00	12,912,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>32,191,693.00</b>	<b>88,595,492.67</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	30,582,000.00	88,595,492.67
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	24,101,492.67
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	30,582,000.00	64,494,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	1,609,693.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,609,693.00	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)</b>	<b>10,456,443.58</b>	<b>22,447,075.35</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>32,813,000.00</b>	<b>6,917,500.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>32,813,000.00</b>	<b>6,917,500.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	32,813,000.00	6,917,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	32,813,000.00	6,917,500.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-32,813,000.00</b>	<b>-6,917,500.00</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-22,356,556.42	15,529,575.35
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	22,356,575.52	19.10
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	19.10	15,529,594.45

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/Төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	385,375,911.00	210,692,089.05	317,633,208.29	913,701,208.34
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	157,980,213.18	157,980,213.18
<b>2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>385,375,911.00</b>	<b>210,692,089.05</b>	<b>475,613,421.47</b>	1,071,681,421.52
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-102,176,467.16	-102,176,467.16
<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>385,375,911.00</b>	<b>210,692,089.05</b>	<b>373,436,954.31</b>	969,504,954.36

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/Төгрөгөөр/	
				Хувь	Өөрчлөлт
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>1,566,580,700.00</b>	<b>1,487,065,486.32</b>	<b>94.92</b>	<b>79,515,213.68</b>
<b>12</b>	<b>Татварын бус орлого</b>	<b>1,566,580,700.00</b>	<b>1,487,065,486.32</b>	<b>94.92</b>	<b>79,515,213.68</b>
120	Нийтлэг татварын бус орлого	108,811,200.00	92,359,207.60	84.88	16,451,992.40
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	108,811,200.00	92,359,207.60	84.88	16,451,992.40
122	Тусламжийн орлого	1,457,769,500.00	1,394,706,278.72	95.67	63,063,221.28
122001	Хандив тусламж /дотоод/	1,457,769,500.00	1,394,706,278.72	95.67	63,063,221.28
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,654,945,700.00</b>	<b>1,471,535,910.97</b>	<b>88.92</b>	<b>183,409,789.03</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,654,945,700.00</b>	<b>1,471,535,910.97</b>	<b>88.92</b>	<b>183,409,789.03</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,549,898,200.00</b>	<b>1,382,940,418.30</b>	<b>89.23</b>	<b>166,957,781.70</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,016,698,900.00</b>	<b>957,439,840.58</b>	<b>94.17</b>	<b>59,259,059.42</b>
210101	Үндсэн цалин	599,620,600.00	543,481,232.18	90.64	56,139,367.82
210102	Нэмэгдэл	260,987,500.00	278,046,115.40	106.54	(17,058,615.40)
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,271,400.00	58,219,733.00	152.12	(19,948,333.00)
210104	Урамшуулал	117,819,400.00	77,692,760.00	65.94	40,126,640.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>129,486,800.00</b>	<b>116,734,832.50</b>	<b>90.15</b>	<b>12,751,967.50</b>
210201	Тэтгэврийн даатгал	88,980,600.00	80,453,489.91	90.42	8,527,110.09
210202	Тэтгэмжийн даатгал	10,126,500.00	9,325,909.29	92.09	800,590.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,063,300.00	5,750,577.76	113.57	(687,277.76)
210204	Ажилгүйдлийн даатгал	5,063,300.00	4,240,951.40	83.76	822,348.60
210205	Эрүүл мэндийн даатгал	20,253,100.00	16,963,904.14	83.76	3,289,195.86
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>77,606,100.00</b>	<b>71,850,216.87</b>	<b>92.58</b>	<b>5,755,883.13</b>
210401	Бичиг хэрэг	6,371,200.00	7,635,960.00	119.85	(1,264,760.00)
210402	Тээвэр, шатахуун	40,985,600.00	40,877,356.87	99.74	108,243.13
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,016,100.00	3,033,000.00	60.47	1,983,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,908,700.00	1,606,200.00	55.22	1,302,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх,	22,324,500.00	18,697,700.00	83.75	3,626,800.00

	ахуйн эд зүйлс				
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>196,751,900.00</b>	<b>149,720,264.35</b>	<b>76.10</b>	<b>47,031,635.65</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	124,891,700.00	103,725,724.35	83.05	21,165,975.65
210502	Хоол, хүнс	41,860,000.00	27,994,540.00	66.88	13,865,460.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	30,000,200.00	18,000,000.00	60.00	12,000,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>67,322,300.00</b>	<b>43,670,800.00</b>	<b>64.87</b>	<b>23,651,500.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,125,200.00	12,810,000.00	115.14	(1,684,800.00)
210602	Тавилга	15,000,000.00	00.00	00.00	15,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	14,182,200.00	10,000,000.00	70.51	4,182,200.00
210604	Урсгал засвар	27,014,900.00	20,860,800.00	77.22	6,154,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,500,000.00</b>	<b>6,408,700.00</b>	<b>85.45</b>	<b>1,091,300.00</b>
210702	Дотоод албан томилолт	7,500,000.00	6,408,700.00	85.45	1,091,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>41,619,900.00</b>	<b>24,203,464.00</b>	<b>58.15</b>	<b>17,416,436.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,557,900.00	21,021,964.00	55.97	16,535,936.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	942,300.00	81.80	209,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	68,100.00	27.24	181,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	32,800.00	9,000.00	27.44	23,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	29,500.00	8,100.00	27.46	21,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	323,700.00	00.00	00.00	323,700.00
210807	Газрын төлбөр	120,000.00	00.00	00.00	120,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,154,000.00	2,154,000.00	100.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>12,912,300.00</b>	<b>12,912,300.00</b>	<b>100.00</b>	<b>00.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,912,300.00	12,912,300.00	100.00	00.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>105,047,500.00</b>	<b>88,595,492.67</b>	<b>84.34</b>	<b>16,452,007.33</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>105,047,500.00</b>	<b>88,595,492.67</b>	<b>84.34</b>	<b>16,452,007.33</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	40,553,500.00	24,101,492.67	59.43	16,452,007.33
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	64,494,000.00	64,494,000.00	100.00	00.00
<b>8</b>	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИИТ ТЭНЦЭЛ</b>	<b>(88,365,000.00)</b>	<b>15,529,575.35</b>		
<b>9</b>	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>88,365,000.00</b>	<b>(15,529,575.35)</b>		
<b>7</b>	<b>Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт</b>	<b>88,365,000.00</b>	<b>(15,529,575.35)</b>		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		19.10		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		15,529,594.45		

Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Өөрчлөлт
1	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>38,976,100.00</b>	<b>37,653,200.00</b>	<b>96.6</b>	<b>1,322,900.0</b>
12	Татварын бус орлого	38,976,100.00	37,653,200.00	96.6	1,322,900.0
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>0.00</b>	<b>70,000.00</b>		<b>(70,000.00)</b>
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	0.00	70,000.00		(70,000.00)
122	Тусламжийн орлого	<b>38,976,100.00</b>	<b>37,583,200.00</b>	<b>96.4</b>	<b>1,392,900.0</b>
122005	Төсвөөс санхүүжих	38,976,100.00	37,583,200.00	96.4	1,392,900.0
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>38,976,100.00</b>	<b>37,653,200.00</b>	<b>96.6</b>	<b>1,322,900.0</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>38,976,100.00</b>	<b>37,653,200.00</b>	<b>96.6</b>	<b>1,322,900.0</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>38,976,100.00</b>	<b>37,653,200.00</b>	<b>96.6</b>	<b>1,322,900.0</b>
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>38,976,100.00</b>	<b>37,653,200.00</b>	<b>96.6</b>	<b>1,322,900.0</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,993,100.00	10,020,399.00	143.3	(3,027,299.00)
210302	Түлш, халаалт	30,983,000.00	27,110,160.00	87.5	3,872,840.00
210303	Цэвэр бохир ус	1,000,000.00	522,641.00	52.3	477,359.00
8	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	-	-		
9	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	-		
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-		

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 156,032.6 мянган төгрөгийн 11 алдаа, зөрчлийг илрүүлснээс 135,627.4 мянган төгрөгийн 7 алдааг залруулж, 20,405.2 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгч, нийцлийн аудиттай холбоотой 2 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

#### 3.1 Залруулсан алдаа

Аудитын явцад илэрсэн дараах алдааг залруулсан. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөний үзүүлэлтийг 108,811.2 мянган төгрөгөөр зөрүүтэй бэлтгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” заалттай нийцэхгүй “толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулгыг хийж, үнэн зөв толилуулсан.
2. Жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэж ирүүлэхдээ тайлант оны худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийг гаргаж ирүүлээгүй, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн маягтын дагуу тайланг бэлтгэж ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7 “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах,” заалттай нийцэхгүй “толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад нөхөж гаргасан.
3. ЭМДС-ийн санхүүжилтийн орлогыг 3,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй толилуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” заалттай нийцэхгүй “толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулгыг хийж, үнэн зөв толилуулсан.
4. Нийгмийн эрүүл мэндийн зардлаас бэлтгэсэн 9,588.2 мянган төгрөгийн бичиг хэрэг, эм, хүнсний материалыг үр дүнгийн тайланд холбогдох зардалд нь бүртгээгүй, бусад зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж

мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулга хийж холбогдох зардалд нь бүртгэсэн.

5. Тэтгэвэрт гарах тэтгэмжийн зардал 10,638.0 мянган төгрөгийг хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжээс гаргаж эдийн засгийн ангилал зөрчсөн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул төрийн сангийн цахим удирдлагын систем болон нягтлан бодох бүртгэлийн программд залруулж бүртгэсэн.
6. Барилгын засварт зарцуулсан 700.0 мянган төгрөгийн материалыг зарлагадаагүй байсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулсан.
7. Ашиглалтад тавьж олгосон нэгээс дээш жилийн хугацаанд ашиглагдах 2,890.1 мянган төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийг тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрч зарлагадсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул ашиглалтад байгаа бусад хангамжийн материалаар бүртгэж залруулсан.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 20,405.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### **3.2. Албан шаардлага**

1. Шилэн дансны цахим хуудсанд 2 төрлийн мэдээллийг 2025 оны 11 дүгээр сард хугацаа хоцроож мэдээлсэн, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;”, 6 дугаар зүйлийн 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;” гэж заасан заалттай нийцэхгүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байгаа нь “нийцсэн бөгөөд зохистой” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Иймд зөрчил таслан зогсоох тухай албан шаардлагыг хүргүүлсэн.
2. Жаргалант сумын эрүүл мэндийн төв нь 2025 онд цахим дэлгүүрээс худалдан авах боломжтой 16,667.1 мянган төгрөгийн эмийг шууд худалдан авсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 “Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна.” заалттай нийцэхгүй “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул зөрчил таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

### **3.3. Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт 1:

- Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн даргын 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн А/18 дугаар тушаалаар байгууллагын ажилчдыг Улаанбаатар хотод эрт илрүүлгийн үзлэгт хамруулах үзлэгийн төлбөр 4,375.0 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлэх бараа, ажил үйлчилгээний зардлаас гаргахдаа Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5.2 заалтыг үндэслэн шилжүүлсэн,
- Байгууллагын шилдэг ажилтны шагналд 5,055.0 мянган төгрөгийг цалингийн зардлаас гаргаж эдийн засгийн ангилал зөрчсөн,
- Ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын шимтгэл, цалингийн бүлэг хооронд 1317.3 мянган төгрөг, эмийн зардлаас 2,302.3 мянган төгрөгийн хоолны гүйлгээ, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас тээврийн хэрэгслийн даатгал, аудитын төлбөр 299.0 мянган төгрөг нийт 3,918.6 мянган төгрөгийн гүйлгээг эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14.1 заалт "Ажил олгогч нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу үйлдвэрлэл, ажил, үйлчилгээтэй холбоотой, зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт ажилтныг хамруулна." ЭМС-ын 2014 оны 34 дүгээр тушаалаар баталсан "Эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгийн журам", "ажил мэргэжлээс хамааран эрүүл мэндийн үзлэг хийх жагсаалт"-тай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Төсвийг батлагдсан эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж байх

**Илрүүлэлт 2:**

Эрүүл мэндийн даатгал хариуцаж E-Health программын хяналт хэрэгжүүлсэн ажилтанд 7,056.5 мянган төгрөгийн нэмэгдэл олгохдоо ЭМДС-ийн санхүүжилтийн хасагдалтын дүнтэй харьцуулж үр дүнг тооцолгүйгээр олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;” заалттай нийцэхгүй “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Эмч нарын ажлыг дүгнэж, үр дүнгийн урамшуулал олгохдоо системд оруулсан мэдээллийн чанар, үр дүнтэй уялдуулах, нэмж үргүй зардал гаргахгүй байх

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/			
							Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруу лаагүй	
Төсвийн гүйцэтгэлийн тайланг зөрүүтэй бэлтгэсэн.	1	108,811.2			1	108,811.2	1	108,811.2		
Батлагдсан маягтын дагуу тайланг бүрэн бэлтгэж ирүүлээгүй	1	-			1	-	1	-		
ЭМДС-ийн санхүүжилтийг	1	3,000.0			1	3,000.0	1	3,000.0		

зөрүүтэй тайлагнасан.									
Нийгмийн эрүүл мэндийн зардаас гарсан зардлыг үр дүнгийн тайланд холбогдох зардлаар бүртгээгүй, бусад зардлаар тайлагнасан.	1	9,588.2			1	9,588.2	1	9,588.2	
Эдийн засгийн ангилал зөрүүтэй гүйлгээ хийж тайлагнасан.	1	10,638.0			1	10,638.0	1	10,638.0	
Барилгын засварт зарцуулсан материалыг зарлагдаагүй	1	700.0			1	700.0	1	700.0	
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийг тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрч зарлагдсан	1	2,890.1			1	2,890.1	1	2,890.1	
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>135,627.4</b>			<b>7</b>	<b>135,627.4</b>	<b>7</b>	<b>135,627.4</b>	

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн.	1	13,348.7					1	13348,7
Е-Health программын хяналт хэрэгжүүлсэн ажилтанд нэмэгдэл олгоходоо ЭМДС-ийн санхүүжилтийн хасагдалтын дүнтэй харьцуулж үр дүнг тооцолгүйгээр олгосон	1	7,056.5					1	7,056.5
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>20,405.2</b>					<b>2</b>	<b>20,405.2</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх мэдээллүүдийг хугацаа хоцроосон.	1	-			1	-		
Цахим дэлгүүрээс худалдан авах боломжтой эм, хэрэгслийг шууд худалдан авсан.	1	-			1	-		
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>-</b>			<b>2</b>	<b>-</b>		

**5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			